



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/108

Мөрөн

Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрт
санхүүжилт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2016 онд Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах зарцуулагдах үндсэн мэргэжил олгох сургалтанд 1345200 төгрөг, эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтанд зарцуулагдах 2500000 төгрөг, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 6154800 төгрөг, нийт 1000000 төгрөгийн санхүүжилт олгосугай.
2. Хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн шилжсэн хөрөнгө оруулалтын зардлаас гаргаж зарцуулахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй .
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Ж.Ганболд/-д, Эрүүл мэндийн газрын дарга /М.Үүрийнбаяр/ нарт үүрэг болгосугай .

ДАРГА

Л.ГАНБОЛД